



## “ЦЭСБ-Аудит” ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дархан нэхий” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангиин аудит

Аудитын код: ДАА-СТА-2024/05

Цахим хуудас: <a href="mailto:www.tsesb.audit@gmail.com">www.tsesb.audit@gmail.com</a>	Захирал аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 95112689
Дархан сум 2024 он	Аудитын менежер: Э.Эрдэнэбат Утас: 99155251 Аудитор: Ш.Ганчимэг Утас: 99377360

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## “ЦЭСБ-АУДИТ” ХХК

Нягтлан бодох бүртгэл, хяналтын  
итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага

4256743, Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баатарын  
5-р хороо. “ЛХА” ХХК-ий 2 давхар 65 тоот  
Утас/факс: 95112689, 89275858

2024. 08. 22. № 2/02  
таний —-ны № —-т

Г Хараат бус аудиторын дүгнэлт

Бид энэхүү “Дархан нэхий” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр тус компанийн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудыг дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланда багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланда багтаагүй мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланда гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг үншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад бидний олж авсан ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

Дээр дурьдсан горимуудыг гүйцэтгэх явцад энэхүү бусад мэдээлэлтэй холбостой материаллаг буруу илэрхийлэл илрүүлсэн бол бид тайлагнах шаардлагатай байдаг. Үүнтэй холбоотой тайлагнах аливаа зүйлс байхгүй.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор компанийн удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, толилуулах нь Компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нехцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлагаа Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторуудын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 91 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох та бүхэнд тайлагнах нь бидний хариуцлага юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Залилан эсвэл алдаанаас үссэн материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олс авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшиний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайландаа үндэслэн гаргасан хэрэглэгчдийн здийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

ЗАХИРАЛ

Ч.ЦЭРЭННАДМИД



**1.1 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дархан нэхий” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийллээ.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дархан нэхий” ХК-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан, Сангийн сайдын тушаалаар батлагдсан ААНБ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын захирал, ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайлангаа НББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

“Дархан нэхий” ХК-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг 2024 оны 02 дугаар сарын 05-наас 2024 оны 02 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор хэрэгжүүлэв.


**1.2 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дархан нэхий” ХК-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 6-г гүйцэтгэв.

Материаллаг байдлын суурийг тус байгууллагын 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн орлогын тайлангийн нийт зарлагын 1 хувиар тооцож 230,223.7 мянган төгрөгөөр тогтоосон болно.



**“Дархан нэхий” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн  
санхүүгийн тайлангийн аудит**

Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нийцсэн байна.

“Дархан нэхий” ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

### **1.3 Дотоод хяналт:**

Бид санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланда материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү хянахдаа “Дархан нэхий” ХК нь байгууллагын дотоод хяналтын систем нь үр нөлөөтэй эсэх, санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гаргахаас сэргийлэхийн тулд жилийн турш үр нөлөөлтэй ажиллах ёстай гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

### **1.4 Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

“Дархан нэхий” ХК нь тайлант онд 19,353,241.3 мянган төгрөгийн орлого, 1,710,992.8 мянган төгрөгийн түрээсийн орлого, 664,294.7 мянган төгөргийн хүүний орлого, 46,679.0 мянган төгрөгийн ногдол ашгийн орлого, 6,760,736.9 мянган төгрөгийн бусад орлого, нийт 28,535,944.7 мянган төгрөгийн орлоготой, 16,189,615.0 мянган төгрөгийн өртөг, 1,635,299.1 мянган төгрөгийн удирдлагын зардал, 2,073,367.3 мянган төгрөгийн бусад зардал, 2,364,401.1 мянган төгрөгийн борлуулалт ба маркетингийн зардал, 759,688.6 мянган төгрөгийн санхүүгийн зардал нийт 23,022,371.1 мянган төгрөгийн зардал гарч, 4,766.4 мянган төгрөгийн бусад ашиг алдагдалтай 5,518,340.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

## **АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### **1. Компанийн товч танилцуулга**

#### **1.1 Товч танилцуулга:**

“Дархан нэхий” ХК нь 1992 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Дархан-Уул аймгийн Дархан сумын Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн, Дархан сумын 13-р баг, үйлдвэрийн район, өөрийн байранд үйл ажиллагаагаа эхэлж байсан байна.

Зорилго:

Бид олон улсын чанар стандартын түвшинд хүрсэн, зах зээлд өрсөлдөх чадвар сайтай, арьс шир болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг шинэ болон шинэчилсэн технологиор үйлдвэрлэж, дотоод, гадаадын зах зээлд борлуулна.

ЦЭСБ-АУДИТ ХХК



## 2. Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэс

### 2.1 Санхүүгийн тайлангийн нийцэл

Компанийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлалгналын Олон Улсын Стандартын (СТОУС) -үүд болон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартуудад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар, журмын”-ын дагуу бэлтгэсэн байна.

### 2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт сууринласан болно. Компани нь мөнгөн гүйлгээнээс бусад санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүнийг аккруэл суурьд үндэслэн бэлтгэсэн.

### 2.3 Өглөг, өр төлбөр

Өглөг, өр төлбөр нь бараа ажил үйлчилгээ худалдан авсны төлөө хүлээж буй хариуцлага бөгөөд ирээдүйд төлөх бодит өртгөөрөө тусгагдана.

### 2.4 Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчийн өмчид оруулсан болон олсон капиталын нийлбэрээр илэрхийлэгдсэн.

### 2.5 Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг үнэн зөв тодорхойлох боломжтой болон эдийн засгийн үр ашиг нь байгууллагад орох нь тодорхой болсон үед буюу худалдан авагчдад бүтээгдэхүүн нийлүүлсэн, ачуулсан дүнгээс борлуулалтын хөнгөлөлт, буцаалт, нэмэгдсэн өргтийн татвар хассан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрч, аккруэл сууриар бүртгэсэн.

### 2.6 Зардал хүлээн зөвшөөрөлт

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь борлуулалтын орлогод ногдох борлогдсон барааны өртөг юм. Өргтийн төвүүдээс бүтээгдэхүүний тоо хэмжээнд суурилан бэлэн бүтээгдэхүүнд хувиарлагдсан өртөгт үндэслэн борлуулсан бүтээгдэхүүний өргтийг тооцдог.


Компанийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатайхолбогдож гарсан бүх зардлыг орлогын тайланд тусгадаг бөгөөд эдгээр зардлыг аккруэл сууриар бүртгэсэн.

### 2.7 Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан нь тайлангийн хугацааны туршид гарсан үндсэн болон хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг харуулдаг.

### 2.8 Санхүүгийн хэрэгглүүр

Тус компанийн хувьд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлага, өглөг нь санхүүгийн хэрэглүүр болдог.



**“Дархан нэхий” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн  
санхүүгийн тайлангийн аудит**

Тодорхой нэг төрлийн санхүүгийн хэрэглүүрийг олж авахад хийгдсэн гэрээний эрх дээр үндэслэн, уг гэрээг байгуулах үйл ажиллагааны зардлыг тооцож оруулсан анхны өргөөр тус санхүүгийн хэрэглүүрийг бүртгэлд тусгадаг.

### **2.9 Орлогын татвар**

Компанийн тайлант үеийн орлогын татварын зардал нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр тооцох бөгөөд өмнөх жилүүдийн татварын өглөгийг тохируулсан хүлээгдэж буй татварын өглөг юм.

### **3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн тухай**

#### **3.1 Тодруулга-Мөнгөн хөрөнгө /Төгрөгөөр/**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Касс-Төгрөг	-	-
Харилцах-Төгрөг	2,809,829,045.34	2,718,161,016.55
Ам.доллар		
<b>Нийт дүн</b>	<b>2,809,829,045.34</b>	<b>2,718,161,016.55</b>

Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тайлант хугацааны цэвэр мөнгөн гүйлгээгээр нэмэгдсэн.

#### **3.2 Тодруулга-Дансны авлага**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Дансны авлага	1,712,965,981.13	1,710,649,554.15
Татвар НДШ-ийн авлага	47,460.0	126,687.70
Бусад авлага	523,400,571.80	660,367,407.85
<b>Нийт дүн</b>	<b>2,236,414,012.93</b>	<b>2,371,143,649.70</b>


#### **3.3 Тодруулга-Бараа материал**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Түүхий эд материал	199,670,332.72	196,673,787.12
Хангамжийн материал	297,402,478.83	352,819,566.07
Дуусаагүй үйлдвэрлэл	3,261,787,563.06	4,161,224,724.14
Боловсруулсан арьс	3,221,822,564.76	2,000,708,699.06
Хими отм/хүнс	3,258,330,924.50	3,355,317,682.00
Бэлэн бутээгдэхүүн	6,498,972,715.25	7,073,464,292.11
<b>Нийт дүн</b>	<b>16,737,986,579.12</b>	<b>17,140,208,750.57</b>

#### **3.4 Урьдчилж төлсөн зардал/тооцоо**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Урьдчилж төлсөн зардал	3,852,250,348.43	3,340,832,092.03
<b>Нийт дүн</b>	<b>3,852,250,348.43</b>	<b>3,340,832,092.03</b>

ЦЭСБ-АУДИТ ХХК



**"Дархан нэхий" ХК-ийн 2023 оны жилийн эцсийн  
санхүүгийн тайлангийн аудит**

**3.5 Үндсэн хөрөнгө**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Газрын сайжруулалт	257,732,804.14	955,352,726.40
Барилга байгууламж	27,327,882,272.44	25,656,175,049.67
Машин тоног төхөөрөмж	3,286,061,629.01	3,535,247,989.71
Тээврийн хэрэгсэл	238,032,407.37	225,999,429.81
Тавилга эд хогшил	839,898,551.45	760,427,727.96
Компьютер бусад хэрэгсэл	40,554,685.95	66,221,248.00
Бусад үндсэн хөрөнгө	60,860,161.06	113,870,442.51
<b>Нийт дүн</b>	<b>32,051,022,511.41</b>	<b>31,313,294,614.06</b>

**3.6 Биет бус хөрөнгө**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Компьютерийн программ хангамж	177,478,813.92	156,744,943.90
<b>Нийт дүн</b>	<b>177,478,813.92</b>	<b>156,744,943.90</b>

**3.7 Өр төлбөр**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Дансны өглөг	831,724,024.70	657,917,770.80
Цалингийн өглөг		
ААНОАТ-ын өглөг	926,694,889.20	626,185,565.90
НӨАТ-ын өглөг	3,745,490,937.30	4,321,834,250.90
ХХОАТ-ын өглөг	182,628,462.10	257,989,646.30
Бусад татварын өглөг	71,989,348.80	349,363,751.70
НДШ-ийн өглөг		
ҮХЭХАТ		2,105,893.80
Бусад богино хугацаат өр төлбөр	859,284,189.1	1,120,234,010.20
Богино хугацаат зээл	6,443,187,332.03	476,062,889.77
<b>Нийт дүн</b>	<b>12,201,714,994.00</b>	<b>6,691,459,769.07</b>

ЦЭСБ-АУДИТ ХХК



Аудитын тайлан

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 502,640.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 502,640.9 мянган төгрөгийн алдааг запруулж, алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

##### 4.1 Залруулсан алдаа

- Нэхий таннери ХХК-ны өмнөх оны ногдол ашгийг өмчийн өөрчлөлтийн тайланд 502,640.9 мянган төгрөгөөр тайлагнасаныг аудитын явцад запруулав.

##### 4.2 Зөвлөмж

**4.2.1 Илрүүлэлт:** Дансны авлага өндөр байгаа нь авлагыг ангилж хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй авлагуудыг тогтоол шийдвэр гаргуулж найдваргүй авлагын нөөц үүсгэх, бүр төлөгдөхгүй тодорхой болсон авлагыг найдваргүй авлагын зардлаар бүртгэх.

**Өгсөн зөвлөмж:** Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул 2022 оны эхний хагас жилд багтаан холбогдох байгууллагуудтай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулах.

**4.2.2 Илрүүлэлт:** Татварын байгууллагад төлөх өглөг их хэмжээгээр хуримтлагдан, төлөгдөхгүй байгаа нь

**Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.23.“Татвар төлөхөөс зугтх” гэж татвар төлөгч татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл нуух зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих үйлдэл, эс үйлдэхүйг; гэсэн заалтыг зөрсөн байна.

**Эрсдэл:** Татварын хяналт шалгалтаар хүү торгуулийн алдангид орох.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн н акт		Албан шаардлаг а		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

ЦЭСБ-АУДИТ ХХК



Аудитын тайлан

**“Дархан нэхий” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн  
санхүүгийн тайлангийн аудит**

1	Дархан нэхий ХХК	3	502,640.9	1	502,640.9	-	-			2	-
---	---------------------	---	-----------	---	-----------	---	---	--	--	---	---



ЦЭСБ-АУДИТ ХХК

Аудитын тайлан

**"ДАРХАН НЭХИЙ" ХК**  
**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
/2023 оны 12 дугаар сарын 31-ээрхи/

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
<b>ХӨРӨНГӨ</b>		
Мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,809,829,045.34	2,718,161,016.55
Дансны авлага	1,712,965,981.13	1,710,649,554.15
Татвар. НДШ-ийн авлага	47,460.00	126,687.70
Бусад авлага	523,400,571.80	660,367,407.85
Бусад санхүүгийн хөрөнгө	6,302,637,181.02	7,935,894,677.23
Бараа материал	16,737,986,579.12	17,140,208,750.57
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	3,852,250,348.43	3,340,832,092.03
Бусад эргэтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	5,884,575,470.09	5,667,689,419.10
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>37,823,692,636.93</b>	<b>39,173,929,605.18</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	32,051,022,461.41	31,313,294,614.06
Биет бус хөрөнгө	177,478,813.95	156,744,943.90
Урт хугацаат ХО		
Бусад биет бус хөрөнгө		
Дуусаагүй барилга	2,626,108,755.15	2,738,186,795.66
<b>Эргэлтийн бус хөгөнгийн дүн</b>	<b>34,854,610,030.51</b>	<b>34,208,226,353.62</b>
Нийт хөгөнгийн дүн	72,678,302,667.44	73,382,155,958.80
Богино хугацаат өр төлбөр		
<b>Өр төлбөр</b>		
Дансны өглөг	831,724,024.68	657,917,770.77
Цалингын өглөг		5,245,294.25
Татварын өглөг	4,926,803,637.35	5,557,479,108.55
НДШ-ийн өглөг	27,411,728.92	140,686,605.41
Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,443,187,332.03	476,062,889.77
Хүүгийн өглөг		
Ногдол ашгийн өглөг	57,235,679.56	
Урьдчилж орсон орлого	1,794,546,720.03	1,193,644,898.34
Неец /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	859,284,189.09	1,120,234,010.17
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>14,940,193,311.66</b>	<b>9,151,270,577.26</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>2,860,526,127.52</b>	<b>4,143,647,449.28</b>
Урт хугацаат зээл	2,780,177,229.21	4,000,027,309.84
Неец /өр төлбөр/	80,348,898.31	34,621,918.60
Хойшлогдсон татварын өр		108,998,220.84
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>17,800,719,439.18</b>	<b>13,294,918,026.54</b>
Халаасны хувьцаа	(16,428,492.00)	(16,428,492.00)
Хувийн өмч	110,547,900.00	110,547,900.00
Нэмж төлөгдсөг капитал	(106,648,582.98)	(106,648,582.98)
Дахин үнэлгээний нэмэгдэл	19,568,028,504.47	19,568,028,504.47
Эздийн өмчийн бусад хэсэг	10,344,592,505.25	10,337,185,574.62
Хуримтлагдсан ашиг	21,335,464,393.52	26,552,526,028.15
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	3,642,027,000.00	3,642,027,000.00
<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>54,877,583,228.26</b>	<b>60,087,237,932.26</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>72,678,302,667.44</b>	<b>73,382,155,958.80</b>

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР

*llh*

Ш.ГАНЧИМЭГ



**"ДАРХАН НЭХИЙ" ХК**  
**АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН**  
**/2023 оны 12 дугаар сарын 31-ээрхи/**

	/төгрөөөр/
Борлуулалтын орлого/цэвэр/	1/1/2023
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	12/31/2023
Нийт ашиг	17,361,702,603.42
Түрээсийн орлого	14,088,754,261.28
Хүүгийн орлого	3,272,948,342.14
Ногдол ашгийн орлого	1,498,359,103.06
Эрхийн шимтгэлийн орлого	391,206,899.55
Бусад орлого	5,631,859,817.25
Борлуулалт. Маркетникийн зардал	1,872,230,247.93
Ерөнхий ба удирдлагын зардал	1,418,910,953.00
Санхүүгийн зардал	16,530,000.00
Бусад зардал	3,285,843,283.05
Гадаад валютын ханшийн зөрүү олз/ гарз	664,294,723.30
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	46,679,053.00
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	1,710,992,786.44
Хөрөнгө оруулалт борлуулнаас үүссэн олз /гарз/	759,688,585.88
Бусад ашиг ( алдагдал)	(3,108,177.64) 4,766,432.51
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>4,230,811,500.38 5,518,340,071.92</b>
Орлогын татварын зардал	532,146,231.13 553,919,425.07
<b>Татварын дараах ашиг алдагдал</b>	<b>3,698,665,269.25 4,964,420,646.85</b>
Зогсоосон ўйл ажиллагааны татварын дараах ashiг алдагдал	3,698,665,269.25 4,964,420,646.85
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>3,698,665,269.25 4,964,420,646.85</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-
Бусад олз (гарз)	-
<b>Орлогын нийт дүн</b>	<b>-</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР

sh

Ш.ГАНЧИМЭГ



**"ДАРХАН НЭХИЙ" ХК**  
**АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**/2023 оны 12 дугаар сарын 31-ээрхи/**


/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Нэмэж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтгүй эрхгүй хувь оролцоо
<b>2021 оны 12 р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>110,547,900.0</b>	<b>(16,428,492.00)</b>	<b>10,344,592,505.25</b>	<b>19,568,028,504.47</b>	<b>(106,648,582.98)</b>	<b>17,636,799,124.27</b>	<b>47,536,890,959.01</b>	<b>3,642,027,000.00</b>
Нягтлан бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нелөө алдааны запруулга							-	-
Залруулсан	110,547,900.0	(16,428,492.00)	10,344,592,505.25	19,568,028,504.47	(106,648,582.98)	17,636,799,124.27	47,536,890,959.01	3,642,027,000.00
Тайлант үеийн							3,698,665,269.25	3,698,665,269.25
Өмчид гарсан								
<b>2022 оны 12 р сарын 31-ээрх</b>	<b>110,547,900.0</b>	<b>(16,428,492.00)</b>	<b>10,344,592,505.25</b>	<b>19,568,028,504.47</b>	<b>(106,648,582.98)</b>	<b>21,335,464,393.52</b>	<b>51,235,556,228.26</b>	<b>3,642,027,000.0</b>
Нягтлан бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нелөө алдааны запруулга						502,640,987.76	502,640,987.76	
Залруулсан үлдэгдэл	110,547,900.0	(16,428,492.00)	10,344,592,505.25	19,568,028,504.47	(106,648,582.98)	21,838,105,381.28	51,738,197,216.02	3,642,027,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг						4,964,420,646.85	4,964,420,646.85	
Өмчид гарсан			(7,406,930.63)				(7,406,930.63)	
Зарласан ногдол ашиг						250,000,000.00	250,000,000.00	
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
<b>2023 оны 12 р сарын 31-ээрх</b>	<b>110,547,900.0</b>	<b>(16,428,492.0)</b>	<b>10,337,185,574.6</b>	<b>19,568,028,504.5</b>	<b>(106,648,583.0)</b>	<b>26,552,526,028.1</b>	<b>56,445,210,932.2</b>	<b>3,642,027,000.00</b>
үлдэгдэл						(0.0)		

ГҮЙЦЭТГЭСЭН АХЛАХ АУДИТОР

*lth*

Ш.ГАНЧИМЭГ



**"ДАРХАН НЭХИЙ" ХК**  
**АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**/2023 оны 12 дугаар сарын 31-ээрх/**

		/ төгрөгөөр/
Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
<b>Мөнгөн орлогоын дүн</b>	<b>27,143,878,374.00</b>	<b>28,375,944,668.24</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	25,912,147,080.00	26,381,141,672.72
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	460,254,286.00	1,231,370,708.99
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	771,477,008.00	763,432,286.53
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>19,416,498,975.44</b>	<b>19,084,993,171.58</b>
Ажиллагсадад төлсөн	4,045,043,715.00	4,570,040,429.80
НДБайгууллагад төлсөн	1,259,519,606.00	1,195,229,180.09
Бараа материал худалдан авахад төлсөн	8,792,094,563.00	7,219,403,955.69
Ашиглалтын зардалд төлсөн	1,382,512,298.00	1,850,613,523.13
Түлш шатахуун тээврийн хэрэгсэлд төлсөн	604,219,916.00	729,687,052.87
Хүүний төлбөрт төлсөн	774,130,211.00	563,288,292.07
Татварын байгууллагад төлсөн	1,568,043,405.00	2,006,322,086.46
Даатгалын төлбөрт төлсөн	21,996,915.00	17,100,789.50
Бусад мөнгөн зарлага	918,942,244.00	821,455,197.85
Борлуулалтын зардалд шилжүүлсэн мөнгө	49,996,102.44	111,852,664.12
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>7,727,379,398.56</b>	<b>9,290,951,496.66</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<b>Мөнгөн орлогоын дүн</b>	<b>627,481,395.00</b>	<b>573,270,666.33</b>
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	50,939,529.00	41,500,000.00
Хүлээн авсан хүүний орлого	271,541,433.00	487,544,642.77
Хүлээн авсан ногдол ашиг		30,825,282.00
Бусад олгосон зээл, буцаалт	305,000,433.00	13,400,741.56
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(1,974,047,794.00)</b>	<b>(4,842,056,082.85)</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,666,840,294.00	716,328,699.48
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,605,500.00	880,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	302,602,000.00	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад олгосон зээл болон урьдчилгаа		4,124,847,383.37
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,346,566,399.00)	(4,268,785,416.52)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b></b>	
<b>Мөнгөн орлогоын дүн</b>	<b>1,579,705,464.78</b>	<b>5,664,495,679.62</b>
Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,500,000,000.00	5,425,747,424.20
Бусдаас авсан урьдчилгаа болон буцаалт	79,705,464.78	226,147,458.75
Валютын ханш		12,600,796.67
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(8,973,940,647.00)</b>	<b>(10,778,329,788.55)</b>
Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,739,707,328.00	10,537,275,692.61
Төлсөн ногдол ашиг	227,869,986.00	235,361,597.00
Төрөл бүрийн хандив	6,363,333.00	5,406,930.00
Бусдаас авсан урьдчилгаа болон буцаалт		285,568.94
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(7,394,235,182.22)</b>	<b>(5,113,834,108.93)</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,013,422,182.66)	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,823,251,228.00	2,809,829,045.34
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,809,829,045.34	2,718,161,016.55

0.00

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР

*sh*

Ш.ГАНЧИМЭГ

